

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

“ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2023 ОНЫ БҮРДҮҮЛЭЛТ,
ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ”

ОРОН НУТГИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ИРГЭДЭД ЧИГЛЭСЭН, ҮР ДҮНТЭЙ
ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙНА

Аудитын код: ДГА-2024/26-7-ШТА-ГА

БҮЛЭГ 1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрээс, хууль, журамд заасны дагуу төлөвлөсөн хэдий ч аймгийн ОНХС-д шилжүүлгийг дутуу олгосон байна.

1.1 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрээс, хууль, журамд заасны дагуу тооцож төлөвлөсөн боловч 1,298.9 сая төгрөг дутуу олгосон байна.

1.1.1 ОНХНС-ийн орлогын бүрдүүлэлт нь тус аудитын газрын шалгах асуудалд хамаарахгүй болно.

1.1.2 ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 2023 оны төсвийн тухай хуулиар батлагдсан төсвөөс дутуу олгосон байна.

УИХ-аас баталсан МУ-ын 2023 оны Төсвийн тухай хуулиар ОНХНС болон улсын төсвөөс аймагт олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 22,531.5 сая төгрөгөөр баталж, төсвийн тодотголоор 4,338.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 26,870.3 сая төгрөгөөр баталсан байна.

УИХ-ын төсвийн тодотголоор 18,602.1 сая төгрөгийг аймгийн ОНХС-д, 8,268.2 сая төгрөгийг сумдын ОНХС-д олгохоор баталснаас ОНХНС-аас нийт 25,571.4 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, батлагдсан төсвөөс 1,298.9 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон байна.

1.1.3 Аймгийн ОНХС-аас сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу олгоогүйгээс 6 суманд олгох орлогын шилжүүлгийг дутуу хуваарилсан байна.

ОНХНС-аас олгосон ОНХС-ийн шилжүүлгийг аймгийн СТСХ, ХОХБТХ аймаг, сумдын хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн аймгийн ОНХС-д 17,250.6 сая төгрөгийн, сумдын ОНХС-д 8,320.8 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус хуваарилсан байна.

ОНХНС-аас олгох орлогын шилжүүлгийг 1,298.9 сая төгрөгөөр дутуу, аймгаас сумдын ОНХС-д 52.6 сая төгрөг илүү шилжүүлснээс шалтгаалан аймгийн ОНХС-ийн санхүүжилтийг 1,351.5 сая төгрөгөөр дутуу хуваарилсан байна.

1.1.4 Орон нутгийн хөгжлийн санд хандив тусламжаас нийт 496.2 сая төгрөгийн санхүүжилтийг төвлөрүүлсэн байна.

Аймаг, сумын ИТХ-ын тогтоолд санхүүжилтийн эх үүсвэрийг ОНХНС-аас олгох шилжүүлэг, олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг, гадаад дотоодын хандив, малын тоо толгойн албан татварын орлого, татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр зэргээс бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гадаад, дотоодын хандив

Аймгийн болон Мандах сумын засаг дарга нар тухайн орон нутагт үйл ажиллагааг явуулж байгаа уул уурхайн компаниудтай нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор хандив тусламж үзүүлэх гэрээг байгуулж аймгийн ОНХС-д 252.4 сая төгрөгийн, Мандах сумын ОНХС-д 243.8 сая төгрөгийн хандивын орлогыг тус тус бүрдүүлсэн байна. Гадаад дотоодын хандив, тусламжийн хэрэгжилт 12.3 хувиар давж биелсэн байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан гэрээний дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламжийн орлогыг Хөвсгөл, Эрдэнэ, Даланжаргалан, Мандах, Өргөн сумдын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэн зарцуулсан зөрчилд ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар Төсвийн тухай хуулийн 60.2.9 заалтыг хэрэгжүүлэн ОНХС-д төвлөрүүлж байх албан шаардлага тогтоосон.

Малын тоо толгойн албан татвар

Малын тоо толгойн албан татварын тухай хууль 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 13 сумын ИТХ-аас 2023 онд тус татварын орлогыг нийт 872.2 сая төгрөгийг төвлөрүүлэхээр баталсан бол, Хөвсгөл сум нь малын тоо толгойн албан татварын орлогыг төлөвлөөгүй байна.

Тайлант онд 14 сум нийт 482.6 сая төгрөгийн малын тоо толгойн албан татварын орлогыг төвлөрүүлэн биелэлт 44.7 хувьтай байна. Энэ нь Малын тоо толгойн албан татварын тухай хуульд заасны дагуу татварын орлогыг тухайн жилийн 7 болон 12 дугаар саруудад төвлөрүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 2023 онд аймгийн хэмжээнд цас эрт орж, цаг агаарын хүнд нөхцөл байдал үүсэж малын хорогдол ихтэй байсантай холбоотойгоор зарим сумдын татварын орлого биелээгүй, уг татварын орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөсөн ТАХ хэрэгжихгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Сангийн өмнөх оны зарцуулагдаагүй үлдэгдэл

ОНХС-ын 2022 оны зарцуулагдаагүй үлдэгдлээс нийт 8,927.4 сая төгрөгийг аймаг, сумдын ИТХ-аар ТАХ-үүдэд санхүүжүүлэхээр баталсан бөгөөд гүйцэтгэлээр нийт 6,992.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Даланжаргалан сум өмнө оноос он дамжин хэрэгжих “ЭМТ-ийн барилгын дотор цэвэр бохир ус, халаалт, агаар сэлгэлт, дотор холбоо дохиолол, дотор цахилгааны ажил”-ын 2023 онд санхүүжих 156.5 сая төгрөгийн төсвийг сумын ИТХ-аар батлуулаагүй байна.

Мөн Дэлгэрэх, Улаанбадрах, Хөвсгөл сумдын ОНХС-ийн 2022 оны санхүүгийн тайлангаар гүйцэтгэгч байгууллагад дутуу олгосон санхүүжилтийн үлдэгдлийг өр төлбөрөөр тусгасан боловч, тайлант онд олгох санхүүжилтийг сумдын ИТХ-аар батлуулаагүй байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар урьд оны үлдэгдлийг орлогын эх үүсвэрт тусган батлуулаагүй зарцуулсан зөрчлийг шийдвэрлэн холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлсэн.

1.2 ОНХС-аар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний 90 хувь нь иргэдийн саналаар дэмжигдсэн, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан ажлуудыг төлөвлөсөн байна.

1.2.1 Тайлант онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээний 92.7 хувь нь иргэдийн саналд тусгагдсан төсөл арга хэмжээ байна.

Сумдын орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр 2023 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө, орон нутгийн хөгжлийг дэмжих, иргэд тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор багийн иргэдээс санал авч ИНХ-аар хэлэлцүүлэн тэмдэглэл хөтлөн эрэмбэлж, ЗДТГ-ын ажлын хэсэгт хүргүүлсэн байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ нь аймгийн төвийн иргэдээс авсан санал, сумдаас ирүүлсэн төсөл арга хэмжээний саналд үндэслэн төлөвлөсөн байна.

Аймаг, сумын ИТХ-ын тогтоолоор 2023 онд ОНХС-ийн хөрөнгөөр нийт 262 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсны 3,500.3 сая төгрөгийн 39-н ТАХ нь өмнө оноос шилжин ирсэн, 34,810.2 сая төгрөгийн 223 ТАХ нь тайлант онд шинээр хэрэгжүүлэх ТАХ байна. Аймаг, сумдын ИТХ-аар батлагдсан ТАХ-ний 92.7 хувь буюу 243 ТАХ нь иргэдийн саналаар дэмжигдсэн, 19 ТАХ нь дэмжигдээгүй ТАХ байна.

Айраг, Даланжаргалан, Өргөн, Хатанбулаг, Хөвсгөл, Эрдэнэ сумд нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6-д заасныг зөрчин иргэдийн санал аваагүй дараах төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

- Айраг сум: Замын гарц, тэмдэг тэмдэглэгээ сайжруулах ажил 10.0 сая төгрөг,
- Даланжаргалан сум: Соёлын төвд техник хэрэгсэл худалдаж авах ажилд 23.2 сая төгрөг,

- Өргөн сум: Гэр хороололд хүүхдийн тоглоомын талбай тохижуулах ажил 8.0 сая төгрөг,
- Хатанбулаг сум: 2024 онд хийгдэх ажлын зураг төсөв, тэгш гудамж, хогийн машины 9-н ширхэг bunker, усны машин, 1-р орон сууцны боловсон 00 засвар зэрэг ажил нийт 393.4 сая төгрөг,
- Хөвсгөл сум: Соёлын төвд нийтийн ариун цэврийн 00 байгуулах, Засаг даргын тамгын газрын 4-н айл засвар хийх, наадмын талбайн засварын ажил, уурын зуухны цахилгаан үүсвэр худалдаж авах, цэцэрлэгийн тоглоомын талбай засварлах, хогны машин худалдан авах зэрэг ажилд нийт 401.1 сая төгрөг,
- Эрдэнэ сум: Хог зөөврийн автомашин худалдан авах, ЕБС-ийн мэдээлэл технологийн кабинетыг тохижуулах, Хилийн 0129 ангийн нэг харуулын байрыг камержуулах, хөдөөгийн багуудын иргэдэд үйлчлэх төвийн тохижилт зэрэг ажилд нийт 85.9 сая төгрөгийн иргэдийн санал аваагүй ТАХ-үүдэд төсвийг тус тус баталсан байна.

Хөвсгөл сумын 2023 оны ОНХС-ийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар дээрх гарсан зөрчлүүдийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлсэн.

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 5.2-д заасны дагуу саналын хуудсаар 5,737 иргэд, цахимаар 1,968 иргэд, бүлгийн ярилцлагаар 317 иргэдээс тус тус санал авсан байна.

Айраг, Дэлгэрэх, Иххэт, Сайхандулаан сумд тус ажлыг дүрэм, журмын дагуу зохион байгуулан ОНХС-н хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээ, хэрэгжүүлэх ажлын иргэдээс ирсэн саналыг багийн ИНХ-ын тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэн эрэмбэлж, сумын Засаг даргын томилсон ажлын хэсэгт хүргүүлж журмыг ханган ажилласан байна.

1.2.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ орон нутгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигтэй уялдсан байна.

Дорноговь аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд үндэсний нэгдмэл үндсэн чиглэл, хүний хөгжил, амьдралын чанар ба дундаж давхарга, эдийн засаг, засаглал, ногоон хөгжил, амар тайван, аюулгүй нийгэм, орон нутгийн хөгжил гэсэн 8 зорилгыг дэвшүүлжээ.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 262 хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь дээрх үндсэн чиглэлийн зорилттой уялдаж буй эсэхийг авч үзэхэд 40 хувь нь “Амар тайван, аюулгүй нийгэм”, 16 хувь нь “Орон нутгийн хөгжил” 15 хувь нь “Хүний хөгжил”, 12 хувь нь “Ногоон хөгжил”, 8 хувь нь “Амьдралын чанар ба дундаж давхарга”, 6 хувь нь “Эдийн засаг”, 3 хувь нь “Засаглал” зорилгыг хангахад тус тус чиглэсэн байгаа нь дэвшүүлсэн зорилттой бүрэн уялдсан байна.

Дорноговь аймаг 2023 онд “Нээлттэй Дорноговь” зорилтыг дэвшүүлэн эдийн засаг, нийгмийн хүндрэлийг давах туулах, хүний хөгжил, эдийн засгийн бодлого, ногоон хөгжлийн бодлого, орон нутаг, хөдөөгийн хөгжил гэсэн 8 зорилгыг дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 238-н ТАХ нь дээрх богино хугацааны бодлогын баримт бичигтэй бүрэн уялдсан байна.

1.2.3 Сумдын ИТХ-ын хурлаар баталсан 678.9 сая төгрөгийн 15 төсөл, арга хэмжээ нь техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөвгүй байна

Аймгийн хэмжээнд 2023 оны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээг хамруулан шалгахад сумдын ИТХ-ын хуралдаанаар техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв батлуулаагүй 678.9 сая төгрөгийн 15 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Тухайлбал:

- Даланжаргалан сум: “Соёлын төвд тоног төхөөрөмж худалдан авах ажил” 23.2 сая төгрөг,
- Эрдэнэ сум: “1,2,3 багуудад гүний өрмийн худаг гаргах ажил” 49.1 сая төгрөг, “Нийтийн эзэмшлийн талбайг камержуулах ажил” 2.5 сая төгрөг,

- Хатанбулаг сум: “Соёлын төвийн лид дэлгэц худалдан авах ажил” 51.2 сая төгрөг, “Соёлын төвийн сандал худалдан авах ажил” 29.7 сая төгрөг,
- Өргөн сум: “Сумын төвийн айл өрхийн 0.4 кв шит болгон оруулгын кабель утаснуудыг шинээр солих ажил” 19.2 сая төгрөг, “Гүний худгийн ажил” 43.4 сая төгрөг,
- Хөвсгөл сум: “Соёлын төвд нийтийн ариун цэврийн өрөө байгуулах” 13.8 сая төгрөг, “ЗДТГ-ын 4-н айлд өргөтгөл, засвар хийх ажил” 19.9 сая төгрөг, “Наадмын талбайн засвар ажил” 173.5 сая төгрөг, “Уурын зуухны цахилгаан үүсгэвэр худалдан авах” 28.2 сая төгрөг, “Цэцэрлэгийн тоглоомын талбай ажил” 43.6 сая төгрөг зэрэг байна.

Сумын ИТХ-аар төсөв тооцоо хийгдээгүй, батлагдсан зураггүй ТАХ-г батлах, зураг төсвийг тогтоол батлагдсаны дараа хийлгэж байгаа нь ажлын төсөвт өртөгт дахин өөрчлөлт орох, чанаргүй хөрөнгө бий болох зэрэг эрсдэлийг үүсгэж байна.

Мөн 2022 онд гүйцэтгэсэн өмнөх аудитаар дээрх алдаа зөрчил илэрч, аудитаар Дэлгэрэх, Иххэт, Мандах, Өргөн, Сайхандулаан, Хөвсгөл, Замын-Үүд сумын Засаг дарга нарт зөвлөмж хүргүүлж, Дэлгэрэх, Иххэт, Сайхандулаан, Замын-Үүд сумд аудитын зөвлөмжийг хэрэгжүүлсэн ажиллаж, Өргөн, Хөвсгөл сумд зөвлөмжийг хэрэгжүүлсэн гэх боловч, хэрэгжилт хангалтгүй зөрчил давтагдан гарсаар байна.

Иймд Өргөн, Хөвсгөл сумдын холбогдох албан тушаалтанд зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан зөрчилд албан шаардлага, Даланжаргалан, Хатанбулаг сумдын холбогдох албан тушаалтанд зөвлөмжийг өгөхөөр шийдвэрлэв.

1.2.4 Аймаг, сумдад ОНХС-аар хийгдэж байгаа төсөл, арга хэмжээ нь тухайн шатны Засаг даргын чиг үүрэгт хамаарсан байна.

Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-д заасан чиг үүргийн дагуу төлөвлөгдсөн байна. Харин өрхийн орлогыг дэмжих чиглэлээр хийгдэх ажил аймаг, сумдын хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдаагүй байна.

Орчны тохижилт, ногоон байгууламж болон иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсролыг дэмжихэд нийт ажлын 60 хувь нь чиглэгдсэн ба үүнд тоглоомын талбай байгуулах, жишиг гудамж, гэрэлтүүлэг, биеийн тамирын талбайн тохижилт, ЭМ, Боловсролын байгууллагын засвар, тоног төхөөрөмжийн нийлүүлэлт, ундны усны цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулах зэрэг ажлууд багтаж байна.

БҮЛЭГ 2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь орон нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангаж, иргэдийн тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн байна

2.1 Аймаг, сумын ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжсэн 238 ТАХ-ний 34,567.8 сая төгрөгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу олгосон байна.

2.1.1 Аймаг, сумын ИТХ-аар батлагдсан 196 ТАХ-д холбогдох журмын дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Аймаг, сумдын ИТХ-аар тайлант онд шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан 34,810.2 сая төгрөгийн 223 төсөл арга хэмжээний 34,140.6 сая төгрөгийн 196 ТАХ-нд ТБОНӨХБАҮХАТХ-ийн хуучин 7.1 болон шинэчлэгдсэн найруулга 31.1 дахь заалтын дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулж 34,259.3 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан байна. Харин сумдын ИТХ-аар батлагдсан 669.6 сая төгрөгийн 27 төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зарлагдаагүй батлагдсан төсөв хэмнэлтээр үлдсэн байна.

Нийт шалгарсан тендерээс нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар 29.929.5 сая төгрөгийн 37, харьцуулалтын аргаар 2,665.3 сая төгрөгийн 46, гэрээ шууд байгуулах аргаар 1,378.4 сая төгрөгийн 96, олон нийтийн оролцоотой худалдан авалтаар 281.2 сая төгрөгийн 17 төсөл, арга хэмжээг тус тус зохион байгуулсан байна.

Тендер сонгон шалгаруулалтын 49.7 хувь нь гэрээ шууд байгуулах аргаар зохион байгуулагдсан нь сумдын ОНХС-гийн хөрөнгөөр бага үнийн дүнтэй арга хэмжээг баталж хэрэгжүүлсэнтэй холбоотой байна.

Аймаг, суманд зарлагдсан ХАА-нд сонгон шалгаруулалтын аргыг мөрдөж ажилласан боловч тендерийн гэрээтэй холбоотой дараах алдаа илэрлээ. Үүнд:

- Айраг сум: Зураг төсөв боловсруулах төсөл арга хэмжээний тухайн онд санхүүжих дүнг сумын ИТХ-ын 2023 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн 12/03 тогтоолоор 13.3 сая төгрөгөөр баталсан, гэтэл “Би Өү Экс Экс” ХХК-тай зураг төслийн ажил гүйцэтгэх №2023/09 дугаартай гэрээг 2023 оны 10 дугаар сарын 06-ны өдөр 25.0 сая төгрөгөөр байгуулж, ХАА-г зохион байгуулалгүй шууд худалдан авалт хийсэн байгаа нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн шинэчилсэн найруулгын 10 дугаар зүйлийн 10.3, 34.1 дэх заалтууд, Засгийн газрын “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 2021 оны 124 дүгээр тогтоолтой тус тус нийцэхгүй байна.
- Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн шууд гэрээ байгуулсан 96 ТАХ-ний 50 орчим хувь нь хяналтын суурь төсөв буюу техник эдийн засгийн үндэслэлгүй сумын ИТХ-аар батлагдаж, тендер зарлахдаа тендерийн тодорхойлолтыг батлагдсан төсөвт багтаан боловсруулж байгаа нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын хавсралтын 4.3.3 дах заалттай нийцэхгүй байна. Мөн тухайн ТАХ нь батлагдсан төсвийн хүрээнд дутуу, чанаргүй хийгдэх, эсвэл хэт өндөр үнээр хийгдэх гэх мэт эрсдэлийг бий болгож байна.
- Зарим сумдад худалдан авах ажиллагааны гэрээний дугаар давхацсан, гэрээ байгуулах эрх олгосон эрх зүйн акт нь байгуулсан гэрээний дараа хүчин төгөлдөр болж гарсан, гэрээний дугаар байхгүй, тендерийн архивын баримтад ажил хүлээлцсэн акт, гэрээний сунгалтын хүсэлт, гэрээний сунгалт зэрэг байхгүй. Үүнд:
 - Даланжаргалан суманд 2 ТАХ-ний гэрээг эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш 14 хоногийн дараа, Сайхандулаан суманд 2 ТАХ-ний гэрээг эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш 43, 54 хоногийн дараа байгуулжээ. Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.2-д “гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын 6-аас доошгүй хоногийн дараа, тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулна” гэж заалттай нийцэхгүй байна.
 - Эрдэнэ сум: Хүүхдийн цэцэрлэгийн гадаа тоглоомын талбай бий болгох ажлын үнийн саналыг “Мандах дуулга” ХХК-аас **1,900.0** мянган төгрөгөөр хийж гүйцэтгэхээр ирүүлж, тендерийг шалгаруулсан байхад ажил гүйцэтгэх гэрээг **1,950.0** мянган төгрөгөөр байгуулан төлбөр тооцоог хийсэн байна.
 - Айраг сум: “Би Өү Экс Экс” ХХК-тай зураг төслийн ажил гүйцэтгэх гэрээг **2023.10.06**-ны өдөр байгуулж, сумын ИТХ-аар төсөв нь **2023.11.29**-ны өдөр батлагдаж, гэрээ байгуулах эрх олгосон захирамж нь **2023.12.15**-ны өдөр гарсан байна.
 - Дэлгэрэх сум: Өвсний нөөц бэлтгэх ажлын гэрээг **2023.06.06**-ны өдөр байгуулж, гэрээ байгуулах эрх олгосон захирамжийн **2023.06.13**-ны өдөр баталсан байна.
 - Өргөн сум: Мал эмнэлгийн үйлчилгээ төсөл арга хэмжээг 2 ААН-тэй шууд гэрээ байгуулан **2023.01.16-2023.12.20** хооронд хийж гүйцэтгүүлж ажлын тайланг, **2023.11.14, 2023.12.20** өдрүүдэд тус тус хүлээн авсан байхад “Вет Тэнүүн сүрэн” ХХК-тай гэрээ байгуулах захирамжийг **2023.12.20**-д гаргаж, гэрээг **2023.12.22**-ны өдөр байгуулсан, “Алтан зуулт” ХХК-тай гэрээ байгуулах захирамжийг **2023.12.28**-д гаргаж, гэрээг **2023.12.27**-ны өдөр тус тус байгуулсан байна.
 - Хатанбулаг сум: Тэгш гудамж төсөл арга хэмжээний гэрээг “Зэс-Орд” ХХК-тай **2023.08.30**-ны өдөр байгуулан эрх олгосон захирамжийг **2023.09.04**-ны өдөр баталсан байна.
 - Эрдэнэ сум: Ерөнхий боловсролын сургуулийн мэдээллийн технологийн кабинетыг тохижуулах ажлын гэрээг “Мандах дуулга” ХХК-тай **2023.05.02**-ны өдөр байгуулан гэрээ байгуулах захирамжийг **2023.05.16**-ны өдөр баталсан байна.

Гэрээ боловсруулахтай холбоотой гарсан алдааг Аудитын явцад засч залруулах талаар чиглэл өгсөн.

2.1.2 ОНХС-ийн санхүүжилтийг ТАХ-ний бодит гүйцэтгэлд үндэслэн олгосон байна.

Аймаг, сумдын ОНХС-ийн харилцах дансны эхний үлдэгдэл 9,817.5 сая төгрөг, тайлант онд нийт 27,575.4 сая төгрөгийг төвлөрүүлж, 34,567.7 сая төгрөгийг зарцуулж эцсийн үлдэгдэл 2,825.2 сая төгрөг болсон байна.

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.6-д заасны дагуу 2023 онд нийт 241 ТАХ-ны 34,567.7 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгосон бөгөөд 90.2 хувийн биелэлттэй тайлагнагдсан байна.

Тайлант онд өмнө оноос шилжиж ирсэн **39 ТАХ**-ны үлдэгдэл санхүүжилтэд 3,500.3 сая төгрөгийн төсөв батлан гүйцэтгэлээр **45 ТАХ**-ны зардалд 3,379.6 сая төгрөгийг зарцуулж 120.7 сая төгрөг хэмнэгдсэн нь зарим ТАХ-ний магадалшгүй ажлын зардал, захиалагч болон зохиогчийн хяналтын зардлуудад гүйцэтгэлийн тайлан ирээгүй улмаас хэмнэлтээр үлдсэн байна.

Даланжаргалан сумын ОНХС-ийн сангаар 2020 оны “Морины шүтээн цогцолбор” 2021 оны “Цэвэрлэх байгууламж” 2 ТАХ-д жил бүр 55.3 сая төгрөгийн төсөв баталж хэрэгжүүлээгүй байна. Аудитаар дээрх 2 ТАХ-нд холбогдох шийдвэрийг гаргуулан авч, арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг Даланжаргалан сумын Засаг даргад өгөв.

Аймаг, сумдын ИТХ-аар тайлант онд нийт шинээр хэрэгжүүлэх 196 ТАХ-ний зардалд 34,140.5 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр ИТХ-аар баталсан 196, батлагдаагүй 2 ТАХ-нд 31,170.1 сая төгрөгийг зарцуулж 2,745.5 сая төгрөгийн хэмнэлттэй тайлагнагдсан байна.

ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд шинээр хэрэгжүүлсэн 199 ТАХ-д хууль, тогтоомжийн дагуу сонгон шалгаруулалтыг явуулж 34,270.8 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан байна. Тайлант онд шинээр хэрэгжүүлсэн ТАХ-ээс Мандах, Сайншанд сумдын 2 ТАХ-нд төсөв батлагдаагүй 33.8 сая төгрөгийг зарцуулагдсан нь “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 2.8, 3.4.1, 8.9 дахь заалтуудтай нийцэхгүй байна. Эдгээр зөрчлүүдэд ОНХС-ийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар холбогдох аудитын шийдвэрүүдийг өгсөн.

2.2 ОНХНС-аас олгох шилжүүлгийг дутуу олгосноос Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт 92.9 хувьтай байна.

2.2.1 Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ нь бүрэн ашиглагдаж байна

Сонгон шалгарсан гүйцэтгэгч байгууллагуудтай 52,319.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 238 ТАХ-ний гэрээг байгуулснаас 2023 онд санхүүжүүлэхээр ИТХ-аар төсөв батлагдсан 235 ТАХ, төсөв батлагдаагүй 3 ТАХ байна.

Нийт хэрэгжүүлэх 238 ТАХ-ээс 46,655.8 сая төгрөгийн өртөгтэй 221 ТАХ-г бүрэн хэрэгжүүлж, 5,663.6 сая төгрөгийн 17 ТАХ-г дутуу хэрэгжүүлэн, сонгон шалгаруулалт хийгдээд гэрээ байгуулсан ТАХ-ээс огт хэрэгжээгүй арга хэмжээ байхгүй байна. Нийт хэрэгжилтийн хувь 92.9 хувьтай байна.

Дутуу хэрэгжсэн ТАХ нь дараах шалтгаантай байна. Тухайлбал:

- Айраг сумын 25.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Зураг төсөв боловсруулах ажил” төсөв оны сүүлд батлагдан гүйцэтгэгч байгууллагад урьдчилгаа санхүүжилт олгосон, зураг төсвийг 2024.01.10-нд хүлээж авахаар гэрээг байгуулсан байна
- Алтанширээ сумын 506.7 сая төгрөгийн төсөвт өртөг 3 ТАХ-ны төсөв төсвийн тодотголоор батлагдан, тендер шалгаруулалтыг 2023 оны 3-р улиралд зохион байгуулсан, гэрээний дуусах хугацаа 2024.06.01-ны өдөр хүртэл байна.
- Алтанширээ сумын 66.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Гэр хорооллын жишиг гудам байгуулах ажил” цаг уурын нөхцөл байдалтай холбогдуулан түр зогсож гэрээний хугацааг 2024.06.01-ны өдөр хүртэл сунгасан байна.
- Даланжаргалан сумын 423.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2000, 2001 онд эхлүүлсэн 2 ТАХ түр зогссон /шүүх, хяналтын байгууллагаар шалгагдаж байгаа/, 2022, 2023 оны 2 ТАХ-ний дуусах хугацааны гэрээг 2024 оны 05 сар бүртгэл сунгасан байна.
- Өргөн сумын 72.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Сумын хог хаягдлыг ангилан төвлөрүүлэх, ангилан ялгах болон аюултай хог хаягдлыг цуглуулах цэг байгуулах ажил”, 9.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Боловсон 00 байгуулах ажил”-ууд **өнөөг хүртэл эхлээгүй**, урьдчилгаа санхүүжилт нийт 35.7 сая төгрөгийг авсан, гэрээний дуусах хугацаа 2023.09.10, гэрээний сунгалт хийгдээгүй байна. Уг 2 ажлыг 1 компани гүйцэтгэж байгаа бөгөөд ажил эхлэх шатандаа орсон, бэлтгэл ажлууд хийгдэж байгаа гэсэн тайлбарыг сумын ЗДТГ-аас өгсөн.
- Сайхандулаан сумын 188.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Баяр наадмын талбай шинээр барих” ажлын гэрээг 2024.07.01 хүртэл сунгасан байна.

- Улаанбадрах сумын 268.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сумын төвийн 0,4 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын ^{шугамыг} шинэчлэх ажил”-ыг хугацаанд нь хийж дууссан, ажил хүлээж авах комисс нэмэлт ажил хийлгэх шийдвэр гарсны дагуу ажлыг хийж, 2024 оны 01.23-ны өдөр ашиглалтад хүлээлгэн өгсөн байна.
- Хөвсгөл сумын 42.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Цэцэрлэгийн тоглоомын талбай засварлах ажил” улирлын байдлаас түр зогсон, гэрээний хугацааг 2024.05.01 хүртэл сунгасан байна.
- Сайншанд сумын 214.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 ТАХ-ний гэрээний хугацааг 2024.03 сар хүртэл сунгасан байна.

Өнөөг хүртэл ажлыг эхлүүлээгүй Өргөн сумын “Сумын хог хаягдлыг ангилан төвлөрүүлэх, ангилан ялгах болон аюултай хог хаягдлыг цуглуулах цэг байгуулах ажил”, “Боловсон 00 байгуулах ажил”-уудыг хэрэгжүүлж дуусгах албан шаардлагыг холбогдох албан тушаалтанд өгөв.

ОНХС-аар хийгдсэн 241.1 сая төгрөгийн 27 арга хэмжээ нь мал эмнэлгийн үйлчилгээ, малчдад зориулсан сургалт, сэг зэм устгал зэрэг үйлчилгээний ажилд зарцуулсан. Харин хөрөнгийн шинжтэй 46,414.7 сая төгрөгийн 194 ТАХ хэрэгжүүлж дуусган бүрэн ашиглагдаж байна.

2.2.2 ОНХС-ийн хөрөнгөөр түрээсийн орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлсэн нь хүн амын ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Иргэдийн ая тухтай амьдрах орчин нөхцөлийг сайжруулахад чиглэсэн ТАХ-г хэрэгжүүлсэн бөгөөд 19.2 хувийг барилга байгууламжийн, 18.8 хувийг тоног төхөөрөмжийн, 13.4 хувийг их засварын, 10.0 хувийг өвсний, 8.8 хувийг мал аж ахуйн, 7.1 хувийг худаг усны, 4.2 хувийг гудамжны гэрэлтүүлэг, 18.5 хувийг авто тээвэр, тэрбум мод, бусад төсөл арга хэмжээний ажлууд тус тус эзэлж байна.



“Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Сайншанд сумын 7-р багт аймгийн ОНХС-ын хөрөнгөөр 13.5 тэрбум төгрөгийн 1152 айлын орон сууцыг барьж, “Түрээсийн орон сууц хөтөлбөр”-ийг хэрэгжүүлсэн. Түрээсийн орон сууцны 1 дүгээр ээлжийн 144 айлын орон сууцанд 2023 оны байдлаар зорилтот бүлгийн 105 иргэн хамрагдаж, журмын дагуу хөгжлийн бэрхшээлтэй 7, ахмад настан 11, өрх толгойлсон эх, эцэг 2, олон хүүхэдтэй гэр бүл 6, залуу гэр бүл 10, эмч, сувилагч, асрагч 14, ерөнхий боловсролын сургуулийн багш 16, цэцэрлэгийн багш 15, малчин 17 айл өрх хамрагдсан байна.

Сумдын төвд хийгдсэн цэвэр, бохир дулааны шугамд холбох, төрийн албан хаагчийг орон сууцаар хангах, сургууль цэцэрлэгийн барилгад засвар үйлчилгээ хийх зэрэг томоохон ажлууд нь иргэдийг хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах, орон нутгийг тэнцвэртэйгээр хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж байна.

2.3 ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон төсөл арга хэмжээг ашиглагч байгууллагад шилжүүлснээр хөрөнгийг ашиглах, хадгалах, хамгаалах нөхцөлийг бүрэн бүрдүүлсэн байна.

2.3.1 ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж байна.

Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-г сумын Засаг даргын захирамжаар ашиглагч байгууллагад шилжүүлсэн байна.

Аудитын явцад ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн аймгийн төвийн 4 ТАХ, Замын-Үүд сумын 8 ТАХ, Алтанширээ сумын 15 ТАХ, Иххэт сумын 5 ТАХ, Өргөн сумын 5 ТАХ, Эрдэнэ сумын 10 ТАХ, нийт 47 ТАХ-ний хөрөнгийн ашиглалтын байдлыг газар дээр нь очиж үзсэн. Дээрх сумдад ОНХС-ын хөрөнгөөр хэрэгжүүлж дуусгавар болсон хөрөнгийг ашиглагч байгууллага бүрэн ашиглаж байсан ба ашиглалт хангалтгүй, эсхүл ашиглаагүй, илүүдэлтэй хөрөнгө аудитын явцад илрээгүй, түүвэрт хамрагдсан хөрөнгийн ашиглалт хэвийн, зориулалтын дагуу ашиглаж байна..

2.3.2 ОНХС-ийн хийсэн эзэмшигч, ашиглагч байгууллагад шилжсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг хууль журмын дагуу хэрэгжүүлж байна.

Аудитын явцад ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдалд үнэлгээ өгөх үүднээс Алтанширээ, Иххэт, Өргөн, Эрдэнэ, Замын-Үүд сумдад ажиллан нөхцөл байдлыг газар дээр нь очиж үзсэн.

Дээрх сумдын хөрөнгийн хадгалалт хамгаалалт хэвийн байсан ба аудитын явцад тус асуудалтай холбоотой материаллаг зөрчил илэрсэнгүй. Харин Сайншанд, Замын-Үүд суманд зарим гэрэлтүүлгийн толгой унасан, Алтанширээ сумын машин өвлийн зуд, хаврын мал сэг зэм устгалын ажилтай холбоотой тэвш, дугуй муудсан байдалтай байсан.

БҮЛЭГ 3. Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй, хэрэгжилтийг журмын дагуу тайлагнаагүй байна.

3.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний гүйцэтгэлийн явцад хяналт тавьж ажилласан ч мөрөөр хийх ажлыг хэрэгжүүлээгүйгээс үр дүн хангалтгүй байна.

3.1.1 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний гүйцэтгэлд холбогдох байгууллагаас тавих хяналт хангалтгүй байна.

ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар 2022 онд гүйцэтгэсэн “2021 оны Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар аймгийн ИТХ-д зөвлөмжийг өгсний дагуу аймгийн ИТХ нь холбогдох арга хэмжээ зохион байгуулж сумдын ИТХ-ын албан хаагчдад хяналтыг тогтмолжуулан сайжруулах, ажлын гүйцэтгэлийг хүлээн авах ажлын хэсэгт хурлын төлөөлөгчдийг оролцуулах гэх мэт заавар зөвлөгөө, зөвлөмжийг өгч, тайлан мэдээг авч нэгтгэн хяналтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Харин сумдын ИТХ-аас ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ний гүйцэтгэлийн явцад хяналт тавих хяналтын хороог томилж хяналт хэрэгжүүлсэн гэх боловч хяналтын тайланд хэчнээн ТАХ-ний явцад хяналт хэрэгжүүлж зөвлөмж, чиглэл өгсөн нь тодорхойгүй байна.

Журамд заасны дагуу сумдын ИТХ нь хяналтын хорооны гишүүдийг арга зүйгээр хангах ажиллаж, тайлан мэдээг тухай бүр авч хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь 2023 онд аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл хөтлөлтөд хяналт шалгалтыг хэрэгжүүлээгүй боловч 2024 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, хяналт шалгалт хийх ажлын удирдамжийн дагуу сумын 2022-2023 оны ОНХС-ийн үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт шалгалтыг хийж эхэлсэн байна.

3.1.2. Захиалагчийн хяналтыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх шаардлагатай байна.

Аймаг, сумдын 2023 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 12,273.9 сая төгрөгийн 66 ТАХ-нд гүйцэтгэсэн захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхээр ажлын төсөвт тусгаснаас, 18 ТАХ-нд хяналтыг хэрэгжүүлж 7,567.7 сая төгрөгийг гэрээ, ажлын тайланг үндэслэн ГХБХБГ, Галба-өөш-Долоодын говийн сав газрын захиргаа, хяналтын 2 инженер гүйцэтгүүлсэн

байна. Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч мэргэжлийн байгууллага, инженерүүд нь ТАХ-ны ил, далд ажлын акт болон гүйцэтгэлийг баталгаажуулах, техникийн тодорхойлолтын дагуу чанартай материалаар гүйцэтгүүлэх, хөдөлмөр хамгаалал, эрүүл аюулгүй байдлыг хангаж ажиллахад анхаарах, талбайн журналыг өдөр тутам хөтлөх, өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг журналд тэмдэглэх зэрэгт анхаарах асуудлаар заавар зөвлөмж өгч илэрсэн зөрчлийг арилгуулан ажилласан байна.

Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхэд мэргэжлийн боловсон хүчний дутагдалтай, хяналт тавих ажлын тоо их, хяналт хэрэгжүүлэх байршил алслагдсан зэргээс шалтгаалж захиалагч хэрэгжиж байгаа ТАХ-ний гүйцэтгэгч, зохиогч, захиалагчийг хамруулсан “Telegram group” үүсгэн ажлын явцын талаар тухай бүр мэдээлэл солилцож, үе шатны ажлын явцыг цахимаар хянаж, хяналт хийх тухай бүрд талбайн журналд өгсөн үүрэг даалгавар, зөвлөмжийг тэмдэглэсэн хэдий ч талбарт ажиллах хяналт хангалтгүй байна.

3.1.3. Өмнөх аудитаар хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжилтийг гарган ирүүлсэн боловч алдаа зөрчлүүд давтагдан гарсаар байна.

ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар “2021 оны Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитыг 2022 онд гүйцэтгэж нийт 12 албан шаардлага, 47 зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлсэн бөгөөд 100 хувийн биелэлттэй гэх боловч ИТХ-аар батлуулаагүй ТАХ-ний санхүүжилтийг олгосон, ИТХ-аар төсөв батлуулахдаа техник, эдийн засгийн үндэслэлгүй ТАХ-ний төсөв батлуулсан, иргэдийн саналаар эрэмбэлэгдээгүй ажлыг батлуулсан гэх мэт алдаа зөрчлүүд давтагдан гаргасаар байна.

Тухайлбал: ОНХС-ийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар дээрх зөрчлүүд гарсан бөгөөд аудитаар төлбөрийн акт тогтоон, албан шаардлага, зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн байна. Үүнд:

- Дэлгэрэх сум: “Иргэдэд үйлчлэх нэг цонхны үйлчилгээний төв” барих ажлын санхүүжилтийг гэрээний үнийн дүнгээс илүү шилжүүлсэн зөрчилд төлбөрийн акт тогтоосон.
- Алтанширээ, Даланжаргалан, Мандах, Хатанбулаг, Эрдэнэ сумдын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ сумын ИТХ-аар төсөв батлагдаагүй, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй ажлуудыг санхүүжүүлсэн зөрчилд зөвлөмж өгсөн.
- Даланжаргалан, Дэлгэрэх, Мандах, Хөвсгөл сумдын шилэн дансны системд мэдээллийг бүрэн байршуулаагүй зөрчилд албан шаардлага, зөвлөмж өгсөн
- Иххэт, Мандах сумдын малын тоо толгойн албан татварын төлөвлөгөө тасарсан зөрчилд зөвлөмж,
- Хөвсгөл сум ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг иргэдийн саналаар эрэмбэлээгүй зөрчилд зөвлөмж өгсөн.
- Хөвсгөл сумын хэрэгжүүлсэн “Ухаалаг худаг” ТАХ-г холбогдох байгууллагын данс бүртгэлд тусгаагүй зөрчилд албан шаардлага өгсөн.

3.2. Төсвийн зарцуулалтын тайлан, мэдээг иж бүрэн, үнэн зөв боловсруулан, холбогдох байгууллагад хүргүүлж, олон нийтэд мэдээлэх шаардлагатай байна.

3.2.1 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн арга хэмжээг холбогдох журам, зааврын дагуу бүрэн тусгаж тайлагнаагүй байна.

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.9-д “ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг сумын ЗДТГ нь дараа оны 02 дугаар сарын 01-ний дотор аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-т, тус хэлтэс нь 3 дугаар сарын 10-ны дотор Сангийн яаманд хүргүүлэх”-ээр заасан боловч аймгийн ХОХБТХ-ээс Сангийн яамд хүргүүлсэн мэдээлэл нь журамд заасан мэдээллийг бүрэн агуулаагүй агуулга дутуу тоон мэдээллийг хүргүүлж байна.

Цаашид ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн ажлын мэдээллийг журамд заасны дагуу бүрэн нэгтгэж, тайлагнаж, аймгийн хэмжээний нэгдсэн судалгаатай болж, мэдээллийн иж бүрэн байх зарчмыг ханган ажиллах нь зүйтэй байна.

3.2.2. Данс бүртгэлд тусгах хөрөнгийн 96.3 хувийг нягтлан бодох бүртгэлд бүртгэсэн байна.

ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжсэн холбогдох байгууллагын нягтлан бодох бүртгэлд тусгах 162 ТАХ-ээс тайлант хугацаанд 159 ТАХ-г бүртгэж тайлагнасан байна.

Эрдэнэ суманд хийгдсэн “Хүүхдийн цэцэрлэгийн гадна талбайн тохижилт”-ын ажлыг НББ-т тусгасан боловч, хөрөнгө тус бүрээр бус бөөн дүнгээр бүртгэж авсан байна.

Өргөн, Сайншанд сумдын ОНХС-ын хөрөнгөөр хийгдэн бүртгэлд тусгаагүй 258.7 сая төгрөгийн 3 хөрөнгийг ашиглагч байгууллагын бүртгэлд тусгах талаар албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

3.2.3. Удирдлагын мэдээллийн системийн ашиглалтыг сайжруулах, мэдээллийг үнэн зөв мэдээлэх шаардлагатай байна.

ОНХС-ийн УМС- нь сум тус бүрээр хэрэгжсэн арга хэмжээний тоо, төсөв, санхүүжилтийг нэгтгэн тайлагнах, арга хэмжээ тус бүрээр тайлагнах гэсэн 2 үндсэн талбартай байна. Системийн нэгтгэн тайлагнах хэсэгт аймгийн хэмжээний ОНХС-ийн мэдээлэл нэгтгэгдэн гардаг бөгөөд 2023 оны мэдээллийн нэгтгэлийг авч үзэхэд батлагдсан төсөв, санхүүжилт, зарцуулалт, гэрээний дүн зэргийг зөрүүтэй тайлагнасан байна.

Тухайлбал:

- Аймаг болон сумдын ОНХС-аар хэрэгжих ажлын батлагдсан төсөв 38,310.5 сая төгрөг, УМС-д 4,411.0 сая төгрөгөөр буюу 33,899.5 сая төгрөгөөр дутуу мэдээлэгдсэн байна.
- Тайлант онд олгосон санхүүжилт 34,571,7 сая төгрөг, УМС-д 83,210 сая төгрөгөөр буюу 48,638.3 сая төгрөгөөр илүү мэдээлэгдсэн.
- Тайлант онд хэрэгжсэн 235 ТАХ-ээс УМС-д 172 мэдээллийг байршуулж 93 ТАХ-г дутуу оруулсан байна.

УМС-д ТАХ тус бүрээр төсөвт өртөг, гэрээний дүн, олгосон санхүүжилт, ажлын явцын зураг зэргийг оруулахаас мэдээллийг зөрүүтэй оруулах, мэдээлэхгүй орхигдуулах, ажлын явцын зургийг оруулаагүй зэрэг нийтлэг зөрчил илэрсэн. Харин Иххэт, Мандах, Сайхандулаан Хатанбулаг сумд УМС-д мэдээллийг цаг тухай бүрт оруулан системийг сайн хөтлөн, ашиглаж байна.

Аймаг сумдын ИТХ-аар батлагдсан ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх 262 ажлын системд оруулсан мэдээллийг шалгахад 32.8 хувь буюу 86 арга хэмжээний мэдээллийг үнэн зөв, 31.7 хувь буюу 83 ажлын мэдээлэл зөрүүтэй, 35.5 хувь буюу 93 ажлын мэдээллийг огт байршуулаагүй байна. Тухайлбал: Хөвсгөл сумын ОНХС нь сумын ИТХ-ийн хурлаар батлагдсан 21 ТАХ-ний 20-ийг нь мэдээлээгүй ба мэдээлсэн 1 ТАХ-ний мэдээллийг дутуу байршуулсан байна.

Системд ТАХ-ний мэдээллийг үнэн зөв, бүрэн оруулахад шат шатны холбогдох албан хаагчдын гүйцэтгэл, хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

3.2.4. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэл, тушаал шийдвэрийг хугацаанд нь мэдээлэх шаардлагатай байна.

Худалдан авах ажиллагааны жилийн тайланг Дэлгэрэх, Хөвсгөл, Замын-Үүд сумд огт мэдээлээгүй бол Өргөн, Хатанбулаг сумд хууль, журамд заасан хугацаанаас хоцорч мэдээлсэн байна. Тайланд тусгасан мэдээллийг шалгахад дараах байдалтай байна.

- Айраг, Иххэт, Сайхандулаан сумд болон Аймаг ажлын гэрээний дүн дутуу, зөрүүтэй тусгасан;

- Мандах сум ТАХ-ний төсөвт өртгийг анхны батлагдсан төсвөөр оруулсан ба дахин шинэчлээгүй;
- Өргөн сум төсөвт өртөг, гэрээний дүнг мөнгөний нэг ижил нэгжээр илэрхийлээгүй /мянган төгрөгөөр, төгрөгөөр/;
- Гүйцэтгэгч байгууллагын мэдээлэл, гэрээ байгуулсан болон дүгнэсэн, урилга нийтэлсэн огноо зэргийг орхигдуулсан зэрэг нийтлэг зөрчил илэрсэн.

Даланжаргалан, Дэлгэрэх, Мандах, Хөвсгөл сумд шилэн дансанд байршуулах мэдээллийг хангалтгүй оруулсан зөрчилд ОНХС-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар албан шаардлага, зөвлөмжийг өгсөн.

Шилэн дансны системд ОНХС-тай холбоотой байршуулах мэдээллийг Улаанбадрах сум маягтын дагуу ажил тус бүрээр үнэн зөв, бүрэн, Хөвсгөл, Эрдэнэ сумдаас бусад сумд сар, жилийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн мэдээллийг цаг хугацаандаа оруулсан байна.

Айраг, Алтанширээ Даланжаргалан Дэлгэрэх Мандах Хөвсгөл Эрдэнэ сумдад ТАХ-г дутуу тайлагнасан, батлагдсан төсөв, гэрээний дүнг зөрүүтэй тусгасан, санхүүжилтийн хэмжээг мэдээлээгүй,

Цаашид ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтын мэдээллийг үнэн зөв, бүрэн байршуулж, ил тод байдлыг хангаж ажиллах шаардлагатай байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- ОНХС-аас аймаг, сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу тооцож гаргасан боловч 1,298.9 сая төгрөг дутуу олгосон байна.
- ОНХС-ийн орлогын эх үүсвэрийг төлөвлөхдөө гадаад, дотоодын хандив тусламжийн орлого, өмнөх оны үлдэгдэл, малын тоо толгойн татварын орлогыг санхүүжилтийн эх үүсвэрт тусгаж батлуулсан байна.
- Сумдад ОНХС-ийн эх үүсвэрээр 2023 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө багийн иргэдээс санал авч ИТХ-аар хэлэлцүүлэх ажил хийгддэг ч зарим сумд иргэдээс санал авч эрэмбэлээгүй ажлыг ИТХ-аар батлуулж, санхүүжүүлсэн байна.
- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээ нь орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдаж, тухайн шатны Засаг даргын чиг үүрэгт хамаарсан байна.
- Төсвийн тооцоолол хийгдээгүй, мэргэжлийн байгууллагын баталсан зураггүй ТАХ-г тухайн сумын ИТХ нь баталж, дараа нь зураг, төсвийг хийлгэж байгаа зөрчил давтагдан гарсаар байна.
- Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд нийт 38,310.5 сая төгрөгийн 262 ТАХ хэрэгжүүлэхээр төлөвлөж, 218 ТАХ бүрэн, 17 ТАХ дутуу, 27 ТАХ-г огт хэрэгжүүлээгүй, нийт гүйцэтгэл 92.9 хувьтай байна. ИТХ-аар батлагдаагүй 3 ТАХ-г 186.8 сая төгрөгөөр санхүүжүүлсэн байна.
- ОНХС-ын хөрөнгөөр хэрэгжүүлсэн “Түрээсийн орон сууц” хөтөлбөр нь зорилтот бүлэгт чиглэсэн хүн амын амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлж, үр дүнтэй хэрэгжсэн байна
- Тухайн шатны ИТХ-аас ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх, хөтөлбөр, ТАХ-ний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлэх хороодыг томилсон ч төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн үе шатанд хэрэгжүүлсэн хяналт тодорхой бус байна.
- Мэргэжлийн байгууллага, мэргэшсэн инженерүүдээр 18 ТАХ-д захиалагчийн хяналтыг хийлгэсэн байна.
- Сангийн яамд хүргүүлсэн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ажлын жилийн нэгтгэл тайланд журамд заагдсан мэдээллүүд бүрэн тусгагдаагүй байна.
- Сангийн хөрөнгөөр хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажлын 96.3 хувийг НББ-д тусгасан байна.

- Удирдлагын мэдээллийн системд нийт ТАХ-ны 86 хувийг үнэн зөв, 83 хувийг зөрүүтэй тусгаж, 25 хувь буюу 93 ажлыг огт мэдээлээгүй байна.

- Шилэн дансны цахим системд тайлан, мэдээг хуулийн хугацаанд байршуулсан боловч сангийн зарцуулалтын мэдээллийг зарим сумд зөрүүтэй мэдээлжээ.

Аудитаар нийт 830.2 сая төгрөгийн 17 зөрчил илрүүлж, зөрчил арилгах, давтан гаргахгүй байх, дутуу ажлыг гүйцэтгүүлэх, хөрөнгө данс бүртгэлд бүртгэх зэрэг нийт 830.2 сая төгрөгийн зөрчилд 10 албан шаардлага, холбогдох албан тушаалтнуудад 7 зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ УЛАМЖЛАХ НЬ:

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулиар 26,870.3 сая төгрөг баталснаас Сангийн яамнаас Дорноговь аймагт ОНХНС-аас олгох шилжүүлгийг 25,871.4 сая төгрөг шилжүүлж, 1,289.9 сая төгрөгөөр дутуу олгосон байгаа нь ОНХС-аар төлөвлөсөн ажил бүрэн хэрэгжихгүй байх эрсдэл үүсгэсэн байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт, нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА ТАНАА

1. Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.9-д заасны дагуу Аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь аймаг, сумын ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж, жил бүрийн 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС-ийн асуудал хариуцсан нэгжид хүргүүлэхдээ журамд заасан 12 мэдээллийг бүрэн тусгаж байх
2. Аймаг болон сумдын ОНХС-ийн Удирдлагын мэдээллийн системийн ашиглалтыг сайжруулах, байршуулсан мэдээллийн үнэн зөв, иж бүрэн байдлыг хянах, арга зүйгээр хангаж ажиллах

ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГА ТАНАА

1. Сумын ОНХС-ийн сангаар 2020 оны “Морины шүтээн цогцолбор” 2021 оны “Цэвэрлэх байгууламж” төсөл арга хэмжээг дуусгах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах

АЙРАГ, АЛТАНШИРЭЭ ДЭЛГЭРЭХ, ЭРДЭНЭ СУМЫН ЗАСАГ ДАРГА НАРТ:

1. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д “тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор” 6.3.9-д “орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэлийг хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор мэдээлнэ гэж заасны дагуу шилэн дансны цахим системд байршуулсан мэдээллийн үнэн зөв, иж бүрэн байдлыг ханган ажиллах